



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 38

Эрдэнэт

Илтгэл, илтгэгчийг батлах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VI хуралдааны бэлтгэл хангасан дүнгийн тухай хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VI Хуралдаанд оруулж хэлэлцүүлэх дараах илтгэл, илтгэгчийг баталсугай.

1. Боловсролын салбарыг 2014-2016 онд хөгжүүлэх хөтөлбөрийн биелэлт, цаашид боловсролын салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр батлах тухай

Илтгэгч нь: Боловсрол, соёл, урлагийн газрын дарга Ж.Бат-Амгалан

2. “Багш” дэд хөтөлбөр батлах тухай

Илтгэгч нь: Нийгмийн бодлогын хэлтсийн дарга А.Бумансор

3. Аймгийн нийгмийн эрүүл мэндийг сайжруулах 2014-2016 онд баримтлах бодлогын биелэлт, аймгийн эрүүл мэндийн салбарыг 2017-2026 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Илтгэгч нь: Эрүүл мэндийн газрын дарга М.Баттүвшин

4. “Эмч” дэд хөтөлбөр батлах тухай.

Илтгэгч нь: Нийгмийн бодлогын хэлтсийн дарга А.Бумансор

5. “Ус” дэд хөтөлбөрийн 2012-2016 онд хэрэгжүүлсэн нэгдүгээр үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2017-2021 онд хэрэгжүүлэх хоёрдугаар үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Илтгэгч нь: Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Ц.Баяржаргал

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА

C:\Togtool \-A4 doc

00100046